



БАГАНУУР ДҮҮРГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

# МАЛ ТООЛЛОГО-2017



2018 он

## ОРШИЛ

Монгол улсын үндсэн хуулинд мал сүргийг үндэсний баялаг мөн хэмээн томъёолж, энэ ч утгаараа мал тооллогын ажлыг улсын хэмжээнд жил бүр зохион байгуулж, үр дүнг нь макро түвшинд хийгддэг тооцоо, судалгаанд ашиглаж, салбарын талаар удирдлагын шийдвэр гаргах мэдээллийн гол эх үүсвэр болгон ашиглаж байна.

Статистикийн тухай Монгол Улсын хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2003 оны 224 дүгээр тогтоолын дагуу аймаг, нийслэл, дүүргийн статистикийн газар, хэлтсүүд жил бүрийн 12 сарын 7-17 өдрүүдэд “Мал, тэжээвэр амьтдын тооллого”-ыг зохион байгуулж явуулдаг билээ.

Үүний дагуу дүүрэгт 2017 оны тооллогыг нийслэлийн Засаг даргын А/909 тоот захирамж, дүүргийн Засаг даргын А/486 тоот захирамжаар энэ оны мал, тэжээвэр амьтдын тооллого явуулах ажлын хэсэг, тэдний ажиллах удирдамжийг батлуулан тооллогын хугацаанд амжилттай зохион байгуулж явууллаа.

Мал тооллогын дүнг нэгтгэн дүгнэсэн энэхүү судалгаа нь дүүргийн мал аж ахуйн салбарын өнөөгийн байдалд дүгнэлт хийж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг боловсруулах, төлөвлөхөд суурь мэдээлэл болно гэдэгт итгэлтэй байна.

## ТОВЧ ТАЙЛБАР, ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

Малтай өрх: Малчин өрхөөс гадна малыг ахуй амьдралдаа туслах чанарын үүрэгтэй өсгөн үржүүлдэг өрхийг хэлнэ.

Малчин өрх: Жилийн 4 улирлын туршид малаа маллаж, малын ашиг шим нь тэдний амьжиргааны эх үүсвэр болгож байгаа өрхийг хэлнэ.

Малчид: Жилийн 4 улирлын туршид мал аж ахуйг эрхэлж, малын ашиг шим нь тэдний амьжиргааны эх үүсвэр болж байгаа 16 ба түүнээс дээш насны хүмүүсийг хэлнэ.

Таван хошуу малыг бодод шилжүүлэх коэффициент:

- 1 тэмээ – 1.5 бод
- 1 адуу – 1 бод
- 1 үхэр – 1 бод
- 6 хонь – 1 бод
- 8 ямаа – 1 бод

Таван хошуу малыг хонин толгойд шилжүүлэх коэффициент:

- 1 тэмээ - 5 хонь
- 1 адуу - 7 хонь
- 1 үхэр - 6 хонь
- 1 хонь - 1 хонь
- 1 ямаа - 0.9 хонь

Нас гүйцсэн мал: Малын төрөл бүр дээр сүүлчийн 2 насны малыг хэлнэ.

- Тэмээ - 4 настай, 5 ба түүнээс дээш настай
- Адуу - 3 настай, 4 ба түүнээс дээш настай
- Үхэр - 2 настай, 3 ба түүнээс дээш настай
- Бог мал /хонь, ямаа/-тухайн жилийн төл малаас бусад насны мал

Өсвөр насны мал:

- Тэмээ - Өнгөрсөн жилийн төл, 2, 3 настай
- Адуу - Өнгөрсөн жилийн төл, 2 настай
- Үхэр - Өнгөрсөн жилийн төл

Төл мал: Тухайн жилийн төлийг хэлнэ.

Бэлэн хээлтэгч: Малын төрөл бүр дээр сүүлийн 2 насны эм малыг хэлнэ.

Малын тоо, толгойн өсөлт: Оны эцсийн малаас оны эхний малыг хасч гаргана. Харьцангуй үзүүлэлтүүдийг гаргахдаа оны эцсийн малын тоог эхний малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлнэ. Малын өсөлтийн орлого тал нь төл бойжилт болон худалдаж авсан, шилжиж ирсэн мал, зарлага тал нь худалдсан, шилжүүлсэн мал болон хэрэглээний зарлага, том малын зүй бусын хорогдол болно.

Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо: Хээлтэгч малын тоог хээлтүүлэгч малын тоонд харьцуулан гаргана.

1 хээлтүүлэгчид ногдох хээлтэгчийн тооны норм нь:

- 1 Буур – 20 ингэ
- 1 Азарга - 10 гүү
- 1 Бух - 25 үнээ
- 1 Хуц, ухна – 50-60 эм хонь, эм ямаа

Малын зүй бусын хорогдолд өвчний (халдвартай, халдваргүй) хорогдол, гэнэтийн аюулын (цас зуд, үер ус, гал түмэр, аянга цахилгаан зэрэг) хорогдол, бусад шалтгааны (малын хариулга, арчилгаа маллагаатай холбогдон гарсан) хорогдлыг оруулна.

Том малын зүй бус хорогдлын оны эхний малд эзлэх хувь: Зүй бусаар хорогдсон малын тоог, оны эхний малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлнэ.

Малын хэрэглээний зарлага: Оны эхний малын тоон дээр бойжуулсан төлийг нэмж, том малын зүй бус хорогдол, оны эцсийн малын тоог хасч гаргана.

Малын хашааны хангамж: Хашааны хангамжийг гаргахдаа хашааны багтаамжийг малын тоонд харьцуулан гаргана. Бод малын хашааны хангамжийг гаргахдаа бодын хашааны багтаамжийг үхрийн тоонд, харин бог малынхыг богийн хашааны багтаамжийг бог малын /хонь, ямаа/ тоонд харьцуулна.

Тэжээл хангамж: Тэжээлийн хангамжийг гаргахдаа тэжээлийн нэгжид шилжүүлсэн тэжээлийн хэмжээг хонин толгойд шилжүүлсэн малын тоонд харьцуулан гаргана. Малын хангамж, бэлчээрийн даацыг гаргахдаа малыг хонин толгойд шилжүүлэн тооцно.

Тэжээлийн нэгжид шилжүүлэх коэффициент: Бэлтгэсэн тэжээл нь илчлэг, чанарын байдлаараа харилцан адилгүй байдаг учраас нэг тэжээлийн нэгжид шилжүүлж тэжээлийн хангамжийг гаргана. Үүний тулд доорхи

- |                         |      |
|-------------------------|------|
| • Хадлан өвс            | 0.45 |
| • Таримал тэжээл        | 0.35 |
| • Даршны ургамал        | 0.25 |
| • Гар тэжээл, хужир шүү | 1.0  |
| • Үр тарианы хаягдал    | 0.9  |
| • Лай                   | 0.4  |
| • Сүрэл                 | 0.25 |
- гэсэн итгэлцүүрүүдийг ашиглан тэжээлийн нэгжид шилжүүлнэ.

Малын тэжээлийн ангилал: Малын тэжээлийг ургамлын гаралтай, амьтны гаралтай, эрдэс тэжээлийн гаралтай гэж ангилна.

Ургамлын гаралтай тэжээлд өвс, сүрэл, үр тариа, буурцгийн төрлийн ургамал орох бөгөөд бүдүүн, хүчит, шүүст тэжээл гэж ангилна. Үүнд:

- Бүдүүн тэжээл - өвс, сүрэл, нэг наст ба олон наст өвс

- Хүчит тэжээл - үр тариа, үр тарианы хаягдал, вандуй, буурцаг
- Шүүст тэжээл – Бүх төрлийн дарш, төмс ногооны хаягдал

Амьтны гаралтай тэжээлд үйлдвэрийн яс, цусны гурил зэрэг орно. Эрдэс тэжээлд давс, хужир шүү орно.

МАЛТАЙ ӨРХ, МАЛЧДЫН ТОО: 2017 оны мал тооллогоор хувийн малтай 712 өрх, үүнээс 437 өрх мал аж ахуй эрхэлж байна. Үүнийг өнгөрсөн онтой харьцуулахад:

Хүснэгт 1. Малтай, малчин өрх, хороогоор


		2014 он	2015 он	2016 он	2017 он
Нийт мал бүхий өрх	1-р хороо	152	149	163	150
	2-р хороо	80	78	78	81
	3-р хороо	150	170	168	166
	4-р хороо	148	160	177	170
	5-р хороо	111	118	138	145
Дүүргийн дүн		641	675	724	712
Үүнээс: Малчин өрх	1-р хороо	68	66	77	89
	2-р хороо	71	62	70	75
	3-р хороо	42	64	76	57
	4-р хороо	87	83	99	130
	5-р хороо	75	58	77	86
Дүүргийн дүн		343	333	399	437

2017 оны байдлаар хувийн малтай 712 өрх байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 12 өрх буюу 1.6 хувиар буурсан байна. Мөн мал аж ахуй эрхэлж, малын ашиг шимийг амьжиргааны эх үүсвэрээ болгон амьдарч байгаа малчин өрх 437 байгаа нь өнгөрсөн оноос 38 өрх буюу 9.5 хувиар өссөн байна.

Хүснэгт 2. Малтай болон малчин өрхийн ам бүл, малчдын тоо

		2014 он	2015 он	2016 он	2017 он
Нийт мал бүхий өрх		641	675	724	712
Түүний ам бүл		2165	2305	2433	2389
Үүнээс: Малчин өрх		343	333	399	437
Түүний ам бүл		1136	1138	1336	1465
Малчдын тоо		570	571	672	649
16-34 насны		117	136	126	152
35-аас тэтгэвэрт гарах насны		339	336	405	335
Тэтгэврийн насны		114	99	141	162
Нийт малчдаас эмэгтэй		258	232	302	277
Насны бүтэц					
16-34 насны		20.5	23.8	18.8	23.4
35-аас тэтгэвэрт гарах насны		59.5	58.8	60.3	51.6
Тэтгэврийн насны		20.0	17.3	21.0	25.0

### Малчдын тоо /насны бүлгээр/



Мал аж ахуйн салбарт 649 малчин ажиллаж байгаа бөгөөд насны бүлгээр авч үзвэл 23.4 хувь нь 16-34 насны, 51.6 хувь нь 35-аас тэтгэвэрт гарах насны, 25.0 хувь нь тэтгэврийн насны хүмүүс байна.

Нийт малчдын 277 нь буюу 42.7 хувь нь эмэгтэй малчид байна.

### МАЛЧДЫН СОЁЛ, АХУЙН ҮЗҮҮЛЭЛТ:




МАЛЫН ТОО, БҮТЭЦ: 2017 оны жилийн эцсийн мал тооллогын дүнгээр мал сүргийн тоо 172049 толгойд хүрч, өнгөрсөн оныхоос 6725 толгой малаар буюу 3.8 хувиар буурсан. Мөн тооллогоор 1575 шувуу, 10 бүл зөгий тоологдсон байна.

### Хүснэгт 3. Малын тоо, төрлөөр

	2014 он	2015 он	2016 он	2017 он	2017/2016	
					зөрүү	хувь
Тэмээ	110	203	209	224	15	7.2
Адуу	10937	11665	14043	13391	-652	-4.6
Үхэр	11091	12319	14198	14563	365	2.6
Хонь	77437	80103	91271	88526	-2745	-3.0
Ямаа	49548	50693	59053	55345	-3708	-6.3
<b>НИЙТ МАЛ</b>	<b>149123</b>	<b>154983</b>	<b>178774</b>	<b>172049</b>	<b>-6725</b>	<b>-3.8</b>

### Малын тоо, оноор



Энэ жилийн тооллогоор тэмээн сүрэг 15 толгой буюу 7.2 хувиар, үхэр сүрэг 365 толгой буюу 2.6 хувиар өссөн бол адуун сүрэг 652 толгой буюу 4.6 хувиар, хонин сүрэг 2745 толгой буюу 3.0 хувиар, ямаан сүрэг 3708 толгой буюу 6.3 хувиар тус тус буурсан байна.

#### Хүснэгт 4. Малын орлого, зарлага, төрлөөр

	Орлого				Зарлага			
	Худалдаж авсан,	шилжиж ирсэн	Бэлэн тоологдсон төл	Зах зээлд борлуулсан	шилжүүлсэн	Алдсан, хулгайлагдсан	Хүнсэнд хэрэглэсэн	Зүй бус хорогдол
Тэмээ	5	2	25	9	5	0	3	0
Адуу	319	1712	2214	1819	2248	108	379	343
Үхэр	457	1641	3853	2215	2167	24	837	343
Хонь	4559	9990	25017	20561	15221	98	5082	1349
Ямаа	3103	7691	13851	10604	13220	83	3208	1238
<b>Дүн</b>	<b>8443</b>	<b>21036</b>	<b>44960</b>	<b>35208</b>	<b>32861</b>	<b>313</b>	<b>9509</b>	<b>3273</b>

Дээрх хүснэгтээс харахад энэ жил бэлэн тоологдсон төлөөр 44960 толгой, худалдаж авсан болон шилжиж ирсэн малаар 29479 толгой мал тус тус нэмэгдэж, харин 35208 толгой мал зах зээлд борлуулагдаж, 32861 толгой мал шилжүүлж, 313 толгой мал алдаж, 9509 толгой мал хүнсэнд хэрэглэж, 3273 толгой мал зүй бусаар хорогдсон байна.

#### Хүснэгт 5. Малын тооны өсөлтөнд нөлөөлсөн үзүүлэлтүүд

	2014 он	2015 он	2016 он	2017 он	2017/2016	
					зөрүү	хувь
Бэлэн тоологдсон төл	44700	46786	51107	44960	-6147	-12.0
Том малын зүй бусын хорогдол	1106	1023	882	3273	2391	271.1
Хээлтэгч малын тоо	69231	72901	82523	80759	-1764	-2.1
Хээл хаясан хээлтэгч	581	541	1221	2007	786	64.4
Сувайрсан хээлтэгч	2887	2532	5059	12191	7132	141.0

Дээрх хүснэгтээс харахад энэ жил том малын зүй бус хорогдол өнгөрсөн оноос 3.7 дахин, хээл хаясан хээлтэгч 1,6 дахин нэмэгдсэн нь малын бууралтанд нөлөөлсөн байна.


**МАЛЫН СҮРГИЙН БҮТЭЦ:** 2017 оны байдлаар нийт мал сүргийн 83.6 хувийг бог мал, 16.4 хувийг бод мал эзэлж байна. Нийт сүргийн бүтцэд таван төрлийн малын эзлэх хувийн жинг төрөл тус бүрээр доорх хүснэгтэнд гарган харуулвал:

Хүснэгт 6. Нийт малд эзлэх хувийн жин, төрлөөр

	2014 он	2015 он	2016 он	2017 он
НИЙТ МАЛ	100.0	100.0	100.0	100.0
Тэмээ	0.1	0.1	0.1	0.1
Адуу	7.3	7.5	7.9	7.8
Үхэр	7.4	7.9	7.9	8.5
Хонь	51.9	51.7	51.1	51.5
Ямаа	33.2	32.7	33.0	32.2

Үүнээс харахад тэмээ, адуу, хонин сүргийн эзлэх хувь сүүлийн 4 жил харьцангуй тогтвортой байна.

Бог малын 61.5 хувийг хонин сүрэг, 38.5 хувийг ямаан сүрэг эзэлж байна.



Энэ жил ямаан сүрэг 55345 толгойд хүрч өмнөх оноос 3708 толгой буюу 6.3 хувиар буурсан байна. Ямаан сүргийн тоо болон бог малын дүнд эзлэх хувь буурсан нь бэлчээрийн даацад эерэгээр нөлөөлж байна.


**МАЛЫН ТОО ХОРООГООР:** Энэ жилийн тооллогоор 1 хороо болон 3 хорооны мал буурч, бусад хороодын мал өссөн дүнтэй байна. Доорх хүснэгтэнд хороодын 2017 онд тоологдсон малыг өмнөх онтой харьцуулан өсөлт бууралтыг тоо болон хувиар харуулж байна.



### Хүснэгт 7. Малын тоо, хороогоор

		2014 он	2015 он	2016 он	2017 он	өсөлт, бууралт	
						тоо	хувь
хороогоор	1-р хороо	40511	39899	52207	42856	-9351	-17.9
	2-р хороо	8476	9845	11838	11964	126	1.1
	3-р хороо	36937	42554	43939	43683	-256	-0.6
	4-р хороо	41239	40806	45843	47027	1184	2.6
	5-р хороо	21960	21879	24947	26519	1572	6.3
Дүүргийн дүн		149123	154983	178774	172049	-6725	-3.8

ХУВИЙН /АМИНЫ/ МАЛЫН ТОО: Мал тооллогоор амины малын тоо 165442 толгойд хүрч нийт малын 96.1 хувийг эзэлж байна. Энэ нь өнгөрсөн оныхоос 7540 толгой малаар буюу 4.4 хувиар өссөн байна. Үүнээс 11 өрхийн 1875 толгой тавиул мал тоологдсон байна.



### Хүснэгт 8. Хувийн малтай өрх, малын тоо

Он	Малтай өрх	Бүгд	Үүнээс:					1 өрхийн дундаж мал
			Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа	
2014	641	142022	110	10748	10761	72320	48083	221.6
2015	675	148558	203	11440	11908	75629	49378	220.1
2016	724	172982	209	13822	13900	87135	57916	238.9
2017	712	165442	224	13076	14110	84506	53526	232.4

2017 оны байдлаар амины малын 32.4 хувийг ямаа, 51.1 хувийг хонь, 7.9 хувийг адуу, 8.5 хувийг үхэр, 0.1 хувийг тэмээ эзэлж байна. Мөн энэ жил 1 өрх дунджаар 232.4 толгой малтай болсон нь өнгөрсөн оноос 6.5 толгой малаар буюу 2.7 хувиар буурсан байна.



Амины малтай 1 өрхөд дунджаар тэмээ 0.3 толгой, адуу 18.4 толгой, үхэр 19.8 толгой, хонь 118.7 толгой, ямаа 75.2 толгой ногдож байна.

**ХУВИЙН /АМИНЫ/ МАЛЫН БҮЛЭГЛЭЛТ:** Нийт малтай өрхийн 44.8 хувь буюу 324 өрх 100 хүртэлх толгой малтай, 17.0 хувь буюу 123 өрх 101-200 толгой малтай, 25.0 хувь буюу 181 өрх 201-500 толгой малтай, 9.9 хувь буюу 72 өрх 501-999 толгой малтай байна.

**Хүснэгт 9. Малтай өрхийн малын бүлэглэлт**

	Өрхийн тоо		Дүнд эзлэх хувь		Малын тоо	
	2016 он	2017 он	2016 он	2017 он	2016 он	2017 он
0-100 малтай	324	302	44.8	42.4	12528	11116
101-200 малтай	123	142	17.0	19.9	17691	21030
201-500 малтай	181	170	25.0	23.9	59011	52169
501-999 малтай	72	73	9.9	10.3	48487	49161
1000-1499 малтай	15	18	2.1	2.5	17230	21659
1500-2000 малтай	5	7	0.7	1.0	8196	12182
2000 дээш малтай	4	-	0.6	-	9839	-
<b>Бүгд</b>	<b>724</b>	<b>712</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>172982</b>	<b>167317</b>

1000 ба түүнээс дээш толгой малтай өрх 25 байгаа нь нийт өрхийн 3.5 хувийг эзэлж байна. Үүний 18 өрх 1000-1499 толгой малтай, 7 өрх 1500-2000 толгой мал тоолуулсан байна. Энэ жил 2000 дээш толгой малтай өрх тоологдоогүй байна.

Малын бүлэглэлт тус бүрээр авч үзэхэд 100 хүртэлх толгой малтай 1 өрхөд дунджаар 36.8 толгой мал, 101-200 малтай 1 өрхөд 148.1 толгой мал, 201-500 малтай 1 өрхөд 306.9 толгой мал, 501-999 малтай 1 өрхөд 673.4 толгой мал, 1000 ба түүнээс дээш малтай 1 өрхөд 1353.6 толгой мал тус тус ногдож байна.



Амины малтай нэг өрх дунджаар 3.4 ам бүлтэй байгаа бөгөөд 1 хүнд 69.1 толгой мал ногдож байна.

**ХЭЭЛТЭГЧ МАЛ:** 2017 оны эцэст 80759 толгой хээлтэгч мал тоологдсон нь өнгөрсөн оныхоос 1764 толгойгоор буюу 2.1 хувиар буурсан ба ингэ 1.4 хувь, үнээ 0.9 хувь, гүү 3.1 хувиар тус тус өсч, эм ямаа 3.1 хувь, эм хонь 2.5 хувиар тус тус буурсан байна.

**Хүснэгт 10. Хээлтэгч мал, төрлөөр**

	2014 он	2015 он	2016 он	2017 он	2017/2016	
					тоо	хувь
Ингэ	37	72	73	74	1	1.4
Гүү	3540	3813	4546	4586	40	0.9
Үнээ	4577	4946	5734	5912	178	3.1
Эм хонь	37761	38652	43929	42832	-1097	-2.5
Эм ямаа	23316	24608	28241	27355	-886	-3.1
<b>Бүгд</b>	<b>69231</b>	<b>72091</b>	<b>82523</b>	<b>80759</b>	<b>-1764</b>	<b>-2.1</b>

Хээлтэгч мал нийт малын 46.9 хувийг эзэлж байгаа бөгөөд

- тэмээн сүргийн – 33.0 хувь
- адуун сүргийн – 34.2 хувь
- үхэр сүргийн – 40.6 хувь
- хонин сүргийн – 48.4 хувь
- ямаан сүргийн – 49.4 хувийг тус тус эзэлж байна.



**БЭЛЭН ТООЛОГДСОН ТӨЛ:** Энэ оны мал тооллогоор бэлэн тоологдсон төлийн тоо 44960 толгой болж өнгөрсөн оныхоос 6147 толгойгоор буюу 12.0 хувиар буурсан байна.

Хүснэгт 11. Бэлэн тоологдсон төл, төрлөөр

	2014 он	2015 он	2016 он	2017 он	2017/2016	
					тоо	хувь
Ботго	23	43	25	25	0	0.0
Унага	2212	2564	2600	2214	-386	-14.8
Тугал	3356	3872	3970	3853	-117	-2.9
Хурга	24369	25693	27973	25017	-2956	-10.6
Ишиг	14740	14614	16539	13851	-2688	-16.3
<b>Бүгд</b>	<b>44700</b>	<b>46786</b>	<b>51107</b>	<b>44960</b>	<b>-6147</b>	<b>-12.0</b>

Өнгөрсөн оны тооллогоор 82523 толгой хээлтэгч төллөхөөр тоологдсон бөгөөд

- хээлтэй малын орлогоор 12926 толгой мал нэмэгдэж
- хээлтэй мал 6806 толгойг зарлагдаж
- хээл хаясан 2007 толгой мал
- сувайрсан 12191 толгой мал тус тус хасагдаж 74413 толгой хээлтэгч төллөсөн нь нийт төллөх насны хээлтэгчийн 90.2 хувь байна.

Хүснэгт 12. Төл бойжилт, төлийн орлого, зарлага, төрлөөр

	Төллөсөн хээлтэгч	Гарсан төл	Хорогдсон төл	Бойжсон төл	Худалдаж авсан шилжиж ирсэн	Худалдсан шилжүүлсэн
Ботго	33	33	1	32	0	7
Унага	3740	3740	145	3595	61	1442
Тугал	5026	5027	183	4844	105	1096
Хурга	40479	40489	1248	39241	591	14815
Ишиг	25135	25141	1121	24020	411	10580
<b>Бүгд</b>	<b>74413</b>	<b>74430</b>	<b>2698</b>	<b>71732</b>	<b>1168</b>	<b>27940</b>

2017 онд 74430 төл хүлээн авсан бөгөөд 2698 төл мал хорогдож төл бойжилт 96.4 хувьтай байна. Өнгөрсөн онд 1 ихэр тугал, 6 ихэр ишиг, 10 ихэр хурга хүлээн авсан байна.

**ТОМ МАЛЫН ЗҮЙ БУС ХОРОГДОЛ:** 2017 оны тооллогоор 3273 том мал хорогдсон бөгөөд энэ нь оны эхний малын 1.8 хувьтай тэнцэж байгаа нь өнгөрсөн оныхоос 2391 толгойгоор буюу 3.7 дахин өссөн байна. Нийт хорогдсон том малын 10.5 хувийг адуу, 10.5 хувийг үхэр, 41.2 хувийг хонь, 37.8 хувийг ямаа эзэлж байна.

Хүснэгт 13. Том малын зүй бусын хорогдол, төрлөөр

	2014 он	2015 он	2016 он	2017 он	2017/2016	
					зөрүү	дахин
Тэмээ	1	-	-	-	-	-
Адуу	91	112	52	343	291	6.6
Үхэр	90	110	155	343	188	2.2
Хонь	467	431	375	1349	974	3.6
Ямаа	457	370	300	1238	938	4.1
<b>Бүгд</b>	<b>1106</b>	<b>1023</b>	<b>882</b>	<b>3273</b>	<b>2391</b>	<b>3.7</b>

Энэ онд хорогдсон нийт малын 79 толгой мал буюу 2.4 хувь нь гэнэтийн аюулаар, 59 толгой мал буюу 1.8 хувь нь өвчнөөр хорогдсон байна.

Хүснэгт 14. Оны эхний малд зүй бус хорогдлын эзлэх хувь

	2014 он	2015 он	2016 он	2017 он
Тэмээ	1.0	0.0	0.0	0.0
Адуу	1.0	1.0	0.4	2.4
Үхэр	1.0	1.0	1.3	2.4
Хонь	0.7	0.6	0.5	1.5
Ямаа	1.1	0.7	0.6	2.1
<b>БҮГД</b>	<b>0.9</b>	<b>0.7</b>	<b>0.6</b>	<b>1.8</b>

**ХЭЭЛТЭГЧ, ХЭЭЛТҮҮЛЭГЧИЙН ТОХИРОО:** 2017 онд 1342 хээлтүүлэгч мал тоологдож өмнөх оноос 69 толгойгоор буюу 4.9 хувиар буурсан байна.

Хүснэгт 15. Хээлтэгч хээлтүүлэгчийн тохироо


	Хээлтүүлэгчийн тоо	Үржлийн норм	2014 он	2015 он	2016 он	2017 он
Ингэ	3	20	37	24	37	25
Гүү	486	10	9	9	9	9
Үнээ	183	25	35	35	33	32
Эм хонь	390	50	101	108	106	110
Эм ямаа	280	60	90	112	93	98

Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо адуун сүргээс бусад сүргийн хувьд алдагдаж байна. Адуу сүрэг дээр зохистой харьцаа харьцангуй хадгалагдаж байгаа нь ажиглагдаж байна.

Үржлийн нормоор бог малын нэг хээлтүүлэгчид 50-60 хээлтэгч ногдох ёстой атал тооллогоор хонь ямаан сүргийн хувьд 110 эм хонь, 98 эм ямаанд 1 хээлтүүлэгч ногдож байгаа нь үржлийн нормоос 1.5-2.0 дахин их байна.

**МАЛЫН БЭЛЧЭЭР, ТЭЖЭЭЛИЙН ХҮРЭЛЦЭЭ, ХАНГАМЖ:**

**БЭЛЧЭЭРИЙН ХҮРЭЛЦЭЭ:** Манай дүүрэг 62020 га газар нутагтай 2017 оны газрын нэгдмэл сангийн тайлангаар 39513.1 га хөдөө аж ахуйн эдэлбэр газар байна. Үүнээс бэлчээрийн талбай 38710.9 га болсон байна. Малын тоо хонин толгойд шилжүүлснээр 320572 толгойд хүрсэн.



Хүснэгт 16. Бэлчээрийн даац

	2014 он	2015 он	2016 он	2017 он
Нийт малын тоо /хонин толгой/	265685	282311	328953	320572
Бэлчээрийн талбай	40360.2	39417.8	39267.7	38710.9
100 га-д ногдох малын тоо	658.3	716.2	837.7	828.1

Дүүргийн 100 га бэлчээрийн талбайд хонин толгойд шилжүүлснээр 828.1 толгой мал ногдож байгаа нь өмнөх оныхоос 9.6 толгой малаар буюу 1.1 хувиар буурсан байна.

## ДҮГНЭЛТ

Багануур дүүрэг 2017 оны мал тооллогын дүнгээр 172049 толгойд хүрч, өнгөрсөн оныхоос 6725 толгой малаар буюу 3.8 хувиар буурлаа. Энэ жилийн малын толгойн бууралтанд доор хүчин зүйлсүүд тухайлбал:

- том малын зүй бус хорогдлын өсөлт
- зах зээлд борлуулсан малын өсөлт
- хээл хаясан эм малын өсөлт
- сувайрсан эм малын өсөлт тус тус нөлөөлсөн байна.

Бог малын бүтцэд 2017 оны байдлаар 61.5 хувийг хонин сүрэг, 38.5 хувийг ямаан сүрэг эзэлж байна.

Энэ онд ямаан сүргийн тоо 55345 толгой хүрч өнгөрсөн оноос 3708 толгой буюу 6.3 хувиар буурсан байна. Бог малын дотор ямаан сүргийн эзлэх хувийн жин 38.4 байгаа нь өнгөрсөн оноос 0.8 пунктээр буурсан байна.

Нийт малын тоо хонин толгойд шилжүүлснээр 320572 толгойд хүрч өмнөх оноос 8381 толгой буюу 2.5 хувиар буурсан байна. Мөн дүүргийн бэлчээрийн талбай 38710.9 га болж өнгөрсөн оноос 556.8 га талбайгаар буюу 1.4 хувиар буурсан байна.

## СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

2018 оны 2 дугаар сарын 5